

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/102/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
2.1.	Оршил	3
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	7
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	7
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11.	Шилэн дансны мэдээлэл	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
3.1	Дотоод аудитын талаар	10
3.2	Түрээсийн бүртгэлийн талаар	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	0
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	4-0
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	5-3

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



Г ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Т.ХЭРҮҮГА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.15 № 06/452
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөө аж ахуйн их сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сургуулийн захирал Т.Хэрүүга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн түрээсийн орлого, дотоод хяналттай зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 03 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Пантер мидланд аудит” ХХК-ийн аудитор Ц.Алтанцэцэг, Д.Билэгсайхан нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөө аж ахуйн их сургууль нь 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа “Пантер мидланд аудит” ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 1/86 дугаар албан бичгээр ирүүлсэн боловч Үндэсний аудитын газарт хүргүүлээгүй байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББООУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хөдөө аж ахуйн их сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хөдөө аж ахуйн их сургууль нь Монгол улсын Дээд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д "...Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино..." гэж заасны дагуу "Амьдралын ухаан, байгаль орчны тэргүүлэх чиглэлээр шинжлэх ухаан, сургалт, үйлдвэрлэл, бизнесийг хосолсон бүс нутгийн манлайлах сургууль болно" гэсэн эрхэм зорилгын хүрээнд суралцагчдыг шинжлэх ухааны судалгааны ололтуудтай танилцуулан, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг ашиглаж бие даасан судалгаа хийх дадалд сурган олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэх зорилт тавин үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Удирдах зөвлөлийн 2013 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар Хөдөө аж ахуйн их сургуулийн дүрмийг баталсан бөгөөд 1.5-д "...Их сургууль нь үндсэн үйл ажиллагааны хувьд ашгийн төлөө бус байгууллага бөгөөд зардлаа нөхөх санхүү, хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх, суралцагч, багш, ажиллагсдын, ажиллах амьдрах орчин, нөхцөл, материаллаг хангамжийг дээшлүүлэх, мэдлэгийн үйлдвэрлэл, бизнес болгох чиглэлээр холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаа явуулна..." гэж заасан байна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хөдөө аж ахуйн их сургуулийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Дээд боловсролын тухай хууль
- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль
- Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”

Тайлант хугацаанд Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийх, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ын дагуу үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг хийсэн байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөдөө аж ахуйн их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг “Баталгаа аудит” ХХК 2016 онд боловсруулсан бөгөөд дараах шалтгааны улмаас шаардлага хангахгүй байна гэж үзэж байна. Үүнд:

- Дансны нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны зааврыг аж ахуйн нэгж байгууллагын дансны ангиллын дагуу хийсэн,
- Санхүүгийн тайлан, түүний тодруулгын маягт нь Сангийн сайдын 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт”-ын дагуу гаргахаар оруулсан,
- Шинээр батлагдсан болон хүчингүй болсон заавар, журмыг тухай бүр нь нэмэлт өөрчлөлтөөр тусгаагүй,

Хөдөө аж ахуйн их сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хөдөө аж ахуйн их сургууль нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамж ашигладаг байна. 2018 оны санхүүгийн тайланд бүрэлдэхүүн 5 салбар болох Эдийн засаг, бизнесийн сургууль, Мал эмнэлгийн сургууль, Агроэкологийн сургууль, Инженер техникийн сургууль, Мал аж ахуй биотехнологийн сургуулиудын санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан байна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянаж үзлээ. Хөдөө аж ахуйн их сургуулийн захиргааны албаны хяналт шинжилгээ үнэлгээ, чанар, дотоод аудит хариуцсан мэргэжилтнүүд 2018 онд хийх ажлын төлөвлөгөөг батлуулан ажилласан боловч

дотоод аудитын мэргэжилтэн нь 2018 оны 9 дүгээр сард БНХАУ-д докторантурт суралцахаар ажлаасаа чөлөөлөгдөж, тухайн албан тушаалд шинээр ажилтан томилогдон ажиллаагүй учир дотоод аудитын төлөвлөсөн ажлууд бүрэн гүйцэд хийгдээгүй байна. Иймд дотоод хяналт “үр нөлөөгүй” байна гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хөдөө аж ахуйн их сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаас сонгосон нь аудитын эрсдэлийг тодорхойлоход санхүүгийн тайланг материаллаг байдлаар алдаатай илэрхийлэгдсэн байж болзошгүй гэж үзсэнтэй холбоотой.

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2018 оны нийт зардал 21,305.3 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 426.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь санхүүгийн тайлангийн хувьд аудитын эрсдэлийг зохистой жишгээр тогтоохтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Хөдөө аж ахуйн их сургуулийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

Оюутнуудад үзүүлсэн сургалтын төлбөрийн хөнгөлөлт 110.7 сая төгрөгийг орлого буруулах бичилт хийж бүртгэсэнээс орлого болон зардал дутуу илэрхийлэгдсэнийг санхүүгийн үр дүнгийн тайланд залруулсан болно.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	16,636.6	
Дүн		2	16,636.6	

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2018 оны завсрын аудитыг “Баталгаа аудит” ХХК гүйцэтгэж жолоочийн сэлбэг, шатахуун зарцуулалтын тооцоог хянах талаар 1 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Засгийн газрын 2018 оны 349 тоот тогтоолоор Сэлэнгэ аймгийн Сант суманд байрлах мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн барилга байгууламжийг сургалтын зориулалтаар Хөдөө аж ахуйн их сургуульд балансаас балансад шилжүүлсэн байна.

Дараагийн аудитаар дээрх барилга, байгууламжийн ашиглалт, хамгаалалт, дуусаагүй барилгын гүйцэтгэлийг хянах, захирлаар ажиллаж байсан Б.Бямбаатай холбоотой авлагын асуудал, оюутны сургалтын төлбөрийн орлого, тус сургууль дээр хэрэгжиж байгаа төслүүдийн талаар нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хөдөө аж ахуйн их сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан Хөдөө аж ахуйн их сургуулийн Удирдах зөвлөлийн тогтоолоор 2018 онд 23,168.0 сая төгрөгийн төсөв баталжээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2018 онд нийт орлого 22,591.4 сая төгрөг буюу 97.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт орлогын 60.5 хувь буюу 13,675.5 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлого, 7.5 хувь буюу 1,703.8 сая төгрөгийг улсын төсвийн санхүүжилт, 32.0 хувь буюу 7,212.1 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлого, төсөл хөтөлбөрийн орлого, хандив тусламж, банкны хүүгийн орлого, нийгмийн даатгалын сангаас олгосон хөнгөлөлт тус тус эзэлж байна. Орлогын төлөвлөгөө тасарсан нь Боловсрол, соёл, шинжлэх, ухаан, спортын яамнаас олгох тогтмол зардлын санхүүжилт 560.0 сая төгрөгөөр дутуу олгогдсонтой холбоотой байна.

2018 оны нийт зардал төсвийн гүйцэтгэлээр 23,604.7 сая төгрөг буюу 101.9 хувьтай байна. Энэ нь тус сургууль дээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн болон хандив тусламжийн орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор төсөл хөтөлбөрийн зардал өссөн, хандив тусламжийн орлогоос дуусаагүй барилгыг санхүүжүүлсэн, сургуулийн 60 жилийн ойн арга хэмжээтэй холбоотой зардлууд өссөнтэй холбоотой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Хөдөө аж ахуйн их сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны www.shilendans.gov.mn сайтад 2018 онд байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний талаарх нийт 950 мэдээллийг оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2017 оны жилийн эцсийн тайланд хийсэн аудитаар 468.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 39.8 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн байна. Өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн ба төлбөрийн актыг бүрэн барагдуулсан байна.

Тус сургуулийн захирал асан Б.Бямбаатай холбоотой авлага барагдуулах 468.0 сая төгрөгийн албан шаардлага хэрэгжээгүй байна. Хан-Уул дүүргийн прокурорын газрын 2018 оны 7 дугаар сарын 17-ны 5/446 тоот мэдэгдэх хуудсаар хэрэг бүртгэлийн ажиллагааг дутуу хийсэн гэж үзэж, хэргийг дахин шалгуулахаар болсон байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөдөө аж ахуйн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хөдөө аж ахуйн их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Дотоод аудитын талаар

3.1.1 Илрүүлэлт: Дотоод аудитын мэргэжилтэн нь 2018 оны 9 дүгээр сард гадаадад суралцахаар 4 жилийн хугацаатай чөлөө авсан ба тухайн албан тушаалд шинээр ажилтан томилж ажиллуулаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2012 оны 129 дүгээр баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.5-д “...Төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нь өөрийн хариуцах асуудлын хамрах хүрээнээс шалтгаалан дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх дотоод аудитор ажиллуулж...” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт сулрах, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаарх мэдээллээр удирдлагыг хангаж чадахгүйд хүрэх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Дотоодын аудитын мэргэжилтэнг томилон ажиллуулах

3.1.4 Байгууллагын өгсөн хариу: Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, баталгаажуулсан болно.

3.2 Түрээсийн бүртгэлийн талаар

3.2.1 Илрүүлэлт: Төрийн өмчийн хороонд төвлөрүүлэх 16.6 сая төгрөгийн өглөгийг орлого бууруулах стандарт бус бичилт хийж бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийгдэх

3.2.3 *Өгсөн зөвлөмж*: Түрээсийн орлогын бүртгэлийг үнэн зөв бүртгэж хэвших

3.2.4 *Байгууллагын өгсөн хариу*: Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, баталгаажуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10 578 418 160,35	8 813 549 813,11
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3 053 620 640,14	2 040 292 335,18
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	175 444,50	354 850,76
31110	Төгрөг	175 444,50	354 850,76
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2 053 445 195,64	1 039 937 484,42
3121	Төгрөг	2 030 718 147,05	1 006 283 761,59
31213	Арилжааны банк дахь харилцах	2 030 718 147,05	1 006 283 761,59
3122	Гадаад валют	22 727 048,59	33 653 722,83
31223	Арилжааны банк дахь харилцах	22 727 048,59	33 653 722,83
31500	Хадгаламж	1 000 000 000,00	1 000 000 000,00
33	АВЛАГА	5 170 226 773,78	4 473 509 809,20
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		343 524 999,17
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	4 161 683 560,78	2 039 741 405,00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	470 642 000,00	1 213 158 000,00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	11 904 265,20	304 265 402,92
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	251 124,06	0,00
335	Бусад авлага	525 745 823,74	572 820 002,11
3351	Байгууллагаас авах авлага		104 801 654,11
3352	Хувь хүмүүсээс авах авлага	525 745 823,74	468 018 348,00
34	УРЬДЧИЛГАА	612 104 179,45	146 871 822,45
34600	Урьдчилж гарсан зардал	399 312 959,17	0,00
3471	Урьдчилгаа тооцоо	212 791 220,28	146 871 822,45
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	36 328 337,72	13 924 280,73
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	13 662 690,00	912 000,00
34713	Цалингийн урьдчилгаа	88 986 455,56	84 155 510,62
34714	Томилолтын урьдчилгаа	73 813 737,00	47 880 031,10
35	БАРАА МАТЕРИАЛ	1 742 466 566,98	2 152 875 846,28
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	31 120 000,00	72 152 940,00
354	Хангамжийн материал	1 673 806 567,07	2 039 147 906,37
35410	Бичиг хэргийн материал	16 841 203,45	30 632 741,64
35430	Сэлбэг хэрэгсэл	924 500,00	9 388 500,00
35450	Барилгын засварын материал	3 497 637,88	26 736 590,55
35460	Хүнсний материал	22 568 500,00	24 337 000,00
35470	Бусад хангамжийн материал	1 629 974 725,74	1 948 053 074,18
35600	Мал амьтад	37 539 999,91	41 574 999,91
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	22 090 970 383,02	47 802 380 635,06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	22 090 970 383,02	47 802 380 635,06
391	Газар		21 084 187 080,00
392	Биет хөрөнгө	21 956 121 981,23	26 609 592 873,43
39201	Барилга, байгууламж, орон сууц	19 918 185 642,18	18 753 779 167,94
39202	Хуримтлагдсан элэгдэл	5 897 851 071,72	282 097 032,31
39203	Авто-тээврийн хэрэгсэл	915 954 403,97	829 324 313,97
39204	Хуримтлагдсан элэгдэл	622 721 737,96	571 046 831,71
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9 072 271 093,20	8 856 733 681,06
39206	Хуримтлагдсан элэгдэл	4 092 680 664,99	4 931 128 233,14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2 170 069 157,68	2 250 817 557,67
39208	Хуримтлагдсан элэгдэл	1 150 718 880,55	1 381 889 863,81
39209	Зам, гүүрийн байгууламж /Нийтийн эзэмшил/	44 991 910,00	747 149 712,22

Хөдөө аж ахуйн их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

